БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2021/37/СТА-ТШЗ


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Глобал капитал аудит ХХК Аудитор: С.Сарантуяа

Утас: 99449299 Цахим хаяг: Sarantuya@gmail.com


Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 10
3.Аудитын тайлан ..... 10
3.1. Ерөнхий зүйл ..... 10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 11
3.4. Материаллаг байдал ..... 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 12
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
3.9. Аудитын илрүүлэлт ..... 14
Залруулсан алдаа ..... 14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 14



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Э.УРТНАСАН ТАНАА

2021.02.25 № 2/84

танай ______________ -ны №______________ -т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн ЭМГ, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг гаргасан байна. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй эмнэлгүүдтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, ажил үйлчилгээний чанарын асуудлыг тухайн шатны засаг дарга хэрэгжүүлдэг.

2021 А4 ТООТ

005020042

Тус байгууллага нь Ковид-19 цар тахлын онцгой дэглэмийн үед Аймгийн онцгой комисс, Эрүүл мэндийн газраас өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 43,216,757.14 | 60,806,635.65 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 43,216,757.14 | 60,806,635.65 |
| 351 | Түүхий эд материал | 3,302,845.00 | 6,840,591.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,066,448.00 | 4,110,770.00 |
| 35130 | Эм боох материал | 1,236,397.00 | 2,729,821.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 00.00 | 276,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 39,913,912.14 | 53,690,044.65 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 151,500.00 | 180,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 279,000.00 | 209,500.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 638,600.00 | 1,000,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 1,015,400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 82,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 889,550.14 | 257,910.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 37,955,262.00 | 50,944,734.65 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 296,116,219.52 | 287,573,376.86 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 296,116,219.52 | 287,573,376.86 |
| 392 | Биет хөрөнгө | 292,112,219.52 | 283,569,376.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 391,257,433.08 | 391,257,433.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -145,018,139.84 | -153,680,419.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 37,805,974.00 | 39,569,540.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -16,724,720.90 | -8,642,040.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 100,806,709.00 | 103,856,709.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -81,037,051.74 | -92,196,029.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,347,294.00 | 16,347,294.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,325,278.08 | -12,943,109.72 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,029,590.00 | 2,029,590.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,029,590.00 | -2,029,590.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,004,000.00 | 4,004,000.00 |
| 39301 | Програм хангамж | 902,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -902,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,004,000.00 | 4,004,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 339,332,976.66 | 348,380,012.51 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 339,332,976.66 | 348,380,012.51 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 339,332,976.66 | 348,380,012.51 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 669,754,429.00 | 669,754,429.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 669,754,429.00 | 669,754,429.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -365,512,052.26 | -356,465,016.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -365,512,052.26 | -365,512,052.26 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 9,047,035.85 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 35,090,599.92 | 35,090,599.92 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 339,332,976.66 | 348,380,012.51 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 338,565,278.00 | 442,969,190.65 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,059,138.00 | 50,023,200.65 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,059,138.00 | 50,023,200.65 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,059,138.00 | 50,023,200.65 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,059,138.00 | 50,023,200.65 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 334,506,140.00 | 392,945,990.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 304,234,600.00 | 343,129,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 304,234,600.00 | 343,129,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 554,900.00 | 5,263,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 551,900.00 | 168,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,000.00 | 5,095,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 20,501,900.00 | 18,591,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,501,900.00 | 18,591,900.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 9,214,740.00 | 25,960,590.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 9,214,740.00 | 25,960,590.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 355,730,656.64 | 419,053,937.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 355,730,656.64 | 419,053,937.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 329,793,424.64 | 405,817,400.17 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 203,690,363.00 | 269,706,896.29 |
| 210101 | Үндсэн цалин | 203,690,363.00 | 269,706,896.29 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,450,523.00 | 33,789,708.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,526,454.00 | 23,032,188.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,070,123.00 | 2,709,679.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,638,177.00 | 2,167,736.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 377,680.00 | 534,555.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,838,089.00 | 5,345,550.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,563,989.00 | 16,090,579.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,989,120.00 | 2,515,710.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,574,869.00 | 13,574,869.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,222,150.00 | 17,782,870.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,399,100.00 | 1,267,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,968,530.00 | 14,000,190.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,393,920.00 | 1,534,080.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 460,600.00 | 981,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 26,266,216.00 | 27,171,190.14 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,111,266.00 | 22,539,580.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,154,950.00 | 4,631,610.14 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,752,000.00 | 2,038,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,752,000.00 | 2,038,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,819,000.00 | 1,494,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,819,000.00 | 1,494,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,049,100.00 | 450,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 450,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,980,083.64 | 37,293,256.74 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,894,550.00 | 9,068,631.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,085,533.64 | 28,224,625.74 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,937,232.00 | 13,236,537.71 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,510,911.00 | 4,365,121.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,510,911.00 | 1,101,321.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 3,263,800.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 24,273,621.00 | 8,871,416.71 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,273,621.00 | 8,871,416.71 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -17,165,378.64 | 23,915,252.77 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 117,250.00 | 14,868,216.92 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 117,250.00 | 14,868,216.92 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | -117,250.00 | -14,868,216.92 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -17,282,628.64 | 9,047,035.85 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 337,153,040.00 | 392,945,990.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 337,153,040.00 | 392,945,990.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 304,234,600.00 | 343,129,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 304,234,600.00 | 343,129,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,201,800.00 | 5,263,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 551,900.00 | 168,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,000.00 | 5,095,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 20,501,900.00 | 18,591,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,501,900.00 | 18,591,900.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 9,214,740.00 | 25,960,590.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 9,214,740.00 | 25,960,590.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 334,253,040.00 | 389,895,990.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 334,253,040.00 | 389,895,990.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 308,315,808.00 | 376,659,452.29 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 203,690,361.00 | 269,706,893.29 |
| 210101 | Үндсэн цалин | 173,108,982.00 | 184,548,715.14 |
| 210102 | Нэмэгдэл | 17,611,735.00 | 64,049,001.34 |
| 210104 | Урамшуулал | 12,969,644.00 | 21,109,176.81 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,450,525.00 | 33,789,711.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,526,457.00 | 23,032,189.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,098,599.00 | 2,709,681.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,638,177.00 | 2,167,736.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 349,204.00 | 534,555.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,838,088.00 | 5,345,550.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,563,989.00 | 16,090,579.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,989,120.00 | 2,515,710.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,574,869.00 | 13,574,869.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,114,250.00 | 18,850,770.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,497,200.00 | 1,296,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,968,530.00 | 14,015,590.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,393,920.00 | 1,534,080.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 455,600.00 | 1,161,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 799,000.00 | 843,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 25,967,433.00 | 20,714,668.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,965,613.00 | 15,928,698.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,001,820.00 | 3,999,970.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 786,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,427,000.00 | 2,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,427,000.00 | 2,400,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,819,000.00 | 1,494,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,819,000.00 | 1,494,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,049,100.00 | 2,850,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,049,100.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 850,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,234,150.00 | 10,762,531.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,234,150.00 | 10,762,531.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,937,232.00 | 13,236,537.71 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,510,911.00 | 4,365,121.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,510,911.00 | 1,101,321.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 3,263,800.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 24,273,621.00 | 8,871,416.71 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,273,621.00 | 8,871,416.71 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 2,900,000.00 | 3,050,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 2,900,000.00 | 3,050,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,900,000.00 | 3,050,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,900,000.00 | 3,050,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,900,000.00 | 3,050,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -2,900,000.00 | -3,050,000.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| С08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 669,754,429.00 | 35,090,599.92 | -365,512,052.26 | 00.00 | 339,332,976.66 |
| D01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 669,754,429.00 | 35,090,599.92 | -365,512,052.26 | 00.00 | 339,332,976.66 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 669,754,429.00 | 35,090,599.92 | -365,512,052.26 | 00.00 | 339,332,976.66 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 9,047,035.85 | 00.00 | 9,047,035.85 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 669,754,429.00 | 35,090,599.92 | -356,465,016.41 | 00.00 | 348,380,012.51 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 388,385,900.00 | 377,709,452.29 | 10,676,447.71 | 97.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 388,385,900.00 | 377,709,452.29 | 10,676,447.71 | 97.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 388,385,900.00 | 377,709,452.29 | 10,676,447.71 | 97.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 269,709,500.00 | 269,706,893.29 | 2,606.71 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 184,550,700.00 | 184,548,715.14 | 1,984.86 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 64,049,600.00 | 64,049,001.34 | 598.66 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 21,109,200.00 | 21,109,176.81 | 23.19 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,843,300.00 | 33,789,711.00 | 53,589.00 | 99.8 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,032,200.00 | 23,032,189.00 | 11.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,709,700.00 | 2,709,681.00 | 19.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,167,800.00 | 2,167,736.00 | 64.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 539,400.00 | 534,555.00 | 4,845.00 | 99.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,394,200.00 | 5,345,550.00 | 48,650.00 | 99.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,191,900.00 | 16,090,579.00 | 1,101,321.00 | 93.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,647,400.00 | 2,515,710.00 | 131,690.00 | 95.0 |
| 210302 | Түлш, халаалт | 14,544,500.00 | 13,574,869.00 | 969,631.00 | 93.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,752,400.00 | 18,850,770.00 | 2,901,630.00 | 86.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,563,000.00 | 1,296,000.00 | 267,000.00 | 82.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,823,400.00 | 14,015,590.00 | 1,807,810.00 | 88.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,016,000.00 | 1,534,080.00 | 481,920.00 | 76.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,400,000.00 | 1,161,600.00 | 238,400.00 | 83.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950,000.00 | 843,500.00 | 106,500.00 | 88.8 |
| 2105 | Нормативт зардал | 21,903,700.00 | 20,714,668.00 | 1,189,032.00 | 94.6 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,023,700.00 | 15,928,698.00 | 95,002.00 | 99.4 |
| 210502 | Хоол, хүнс | 4,000,000.00 | 3,999,970.00 | 30.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,880,000.00 | 786,000.00 | 1,094,000.00 | 41.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,691,800.00 | 5,450,000.00 | 5,241,800.00 | 51.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,291,800.00 | 3,050,000.00 | 5,241,800.00 | 36.8 |
| 210604 | Урсгал засвар | 2,400,000.00 | 2,400,000.00 | 0.00 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,657,200.00 | 1,494,300.00 | 162,900.00 | 90.2 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,657,200.00 | 1,494,300.00 | 162,900.00 | 90.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 850,000.00 | 850,000.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 850,000.00 | 850,000.00 | 0.00 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10786100.00 | 10762531.00 | 23,569.00 | 99.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,786,100.00 | 10,762,531.00 | 23,569.00 | 99.8 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 388,385,900.00 | 377,709,452.29 | 10,676,447.71 | 97.3 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 343,129,300.00 | 334,258,283.29 | 8,871,016.71 | 97.4 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 343,129,300.00 | 334,258,283.29 | 8,871,016.71 | 97.4 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 18,591,900.00 | 17,490,579.00 | 1,101,321.00 | 94.1 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 18,591,900.00 | 17,490,579.00 | 1,101,321.00 | 94.1 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 26,664,700.00 | 25,960,590.00 | 704,110.00 | 97.4 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 26,664,700.00 | 25,960,590.00 | 704,110.00 | 97.4 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 22.00 | 22.00 | 0.00 | |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 | 0.00 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | 5,500.00 | 5,511.00 | -11.00 | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 22.00 | 22.00 | 0.00 | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 16.00 | 16.00 | 0.00 | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 06.00 | 0.00 | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 5,263,800 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 5,263,800 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 5,263,800 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 5,263,800 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 5,263,800 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 5,263,800 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,263,00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Э.Уртнасан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 13-аас 2021 оны 02 дугаар сарын 15–ний хооронд Баянхонгор аймаг дахь Глобал Капитал аудит ХХК-ны газрын аудитор С.Сарантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 11 дүгээр сарын 02-ний өдрийн 226 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг оновчтой хэрэгжүүлэх үйлчлүүлэгчдэд ээлтэй тэгш хүртээмжтэй чанартай тусламж үйлчилгээг хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино, гэсэн зорилтын дэвшүүлэн ажиллажээ.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 355847,9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7116,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 373902,5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7478,0 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 348380.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 5202,9 мянган төгрөгөөр буюу 1,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 43,216.8 | 60,806.6 | 17,589.9 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 43,216.8 | 60,806.6 | 17,589.9 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 296,116.2 | 287,573.4 | (8,542.8) |
| Үндсэн хөрөнгө | 553,153.0 | 557,514.6 | 4,361.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (257,036.8) | (269,941.2) | (12,904.4) |
| **Нийт хөрөнгө** | 339,333.0 | 348,380.0 | 9,047.0 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 339,333.0 | 348,380.0 | 9,047.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 339,333.0 | 348,380.0 | 9,047.0 |

Бараа материалын дансны үлдэгдэл 60806,6 мянган төгрөг болж 17589,9 мянган төгрөгөөр өссөн нь эм, эмнэлгийн хэрэгслийн дансны үлдэгдэл нэмэгдэж цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор 8448,5 мянган төгрөгийн хөрөнгийг ЭМГ-аас үнэ төлбөргүй, ирсэн хөрөнгүүд 9141,4 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 557514,6 мянган төгрөг болж 34550,0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3050,0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2020.05.18-ны өдрийн А/297 тоот тушаалаар хандиваар 31500,0 мянган төгрөгийн орлого авч, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.31-ны өдрийн 51 дугаартай тогтоолоор Хатан суудлын заставын эмнэлэгт шилжүүлэн өгсөн 29736,4 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 348380,0 мянган төгрөг болж 9047,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 9047,1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 442969,1 мянган төгрөг болж, өмнөх оноос 104403,9 мянган төгрөгөөр буюу 76,4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй орлого байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 16745,8 мянга, үнэ төлбөргүй орлогоор 45964,1 мянга, санхүүжилтийн орлого 38895,1 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансанд ажилчдын 5 жилийн тэтгэмж 1 хүний 5095,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 419053,9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 63323,3 мянган төгрөгөөр буюу 1,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, НДШ-ийн зардал 71662,5 мянган төгрөгөөр зардал нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 394028,6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 394028,6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 394028,6 мянган төгрөгийн төсөв баталснаас 388385,9 мянган төгрөгийг улсын төсвөөс 5642,7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 4 арга хэмжээний 7563,0 мянган төгрөг дутуу зарцуулсан нь 81603 арга хэмжээ 2606,7 мянган төгрөгөөр, 80302 арга хэмжээ 5360,3 мянган төгрөг дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

| Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| НИЙТ | | 388,385,900.00 | 379,709,452 | 8,676,447.00 | |
| Хөтөлбөр71602 | Баян-өндөр сумын ЭМТ | 68,015,000.00 | 52,160,187.00 | 15,854,813.00 | 76.7 |
| Арга хэмжээ 80109 | ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 18,591,900.00 | 17,490,579.00 | 1,101,321.00 | 94.1 |
| | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,191,900.00 | 16,090,579.00 | 1,101,321.00 | 93.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,647,400.00 | 2,515,710.00 | 131,690.00 | 95.0 |
| 210302 | Түлш, халаалт | 14,544,500.00 | 13,574,869.00 | 969,631.00 | 93.3 |
| | Эд хогшил худалдан авах | 1,400,000.00 | 1,400,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,400,000.00 | 1,400,000.00 | 0.00 | 100.0 |
| Арга хэмжээ 80302 | Бараа үйлчилгээний зардал | 22,539,400.00 | 17,179,029.00 | 5,360,371.00 | 76.2 |
| | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,611,500.00 | 2,516,498.00 | 95,002.00 | 96.4 |
| | Эд хогшил худалдан авах | 8,291,800.00 | 3,050,000.00 | 5,241,800.00 | 36.8 |
| 213205 | Багаж,техник,хэрэгсэл | 8,291,800.00 | 3,050,000.00 | 5,241,800.00 | 36.8 |
| | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр | 850,000.00 | 850,000.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит бат, зэрэглэл тогтоох | 850,000.00 | 850,000.00 | 0.00 | 100.0 |
| | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,786,100.00 | 10,762,531.00 | 23,569.00 | 99.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,786,100.00 | 10,762,531.00 | 23,569.00 | 99.8 |
| Хөтөлбөр71602 | | | | | |
| Арга хэмжээ 81603 | | | | | |
| | нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 347,254,600.00 | 343,039,844.29 | 4,214,755.71 | 98.8 |
| | Урсгал зардлын дүн | | | | |
| | Бараа үйлчилгээний зардал | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ 81603 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 269,709,500.00 | 269,706,893.29 | 2,606.71 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 184,550,700.00 | 184,548,715.14 | 1,984.86 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 64,049,600.00 | 64,049,001.34 | 598.66 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 21,109,200.00 | 21,109,176.81 | 23.19 | 100.0 |
| | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,843,300.00 | 33,789,711.00 | 53,589.00 | 99.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,032,200.00 | 23,032,189.00 | 11.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,709,700.00 | 2,709,681.00 | 19.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,167,800.00 | 2,167,736.00 | 64.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 539,400.00 | 534,555.00 | 4,845.00 | 99.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,394,200.00 | 5,345,550.00 | 48,650.00 | 99.1 |
| | Хангамж,Бараа материалын зардал | 21,752,400.00 | 18,850,770.00 | 2,901,630.00 | 86.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,563,000.00 | 1,296,000.00 | 267,000.00 | 82.9 |
| 210402 | Тээвэр шатахуун | 15,823,400.00 | 14,015,590.00 | 1,807,810.00 | 88.6 |
| 210403 | Шуудан холбоо,интернэтийн төлбөр | 2,016,000.00 | 1,534,080.00 | 481,920.00 | 76.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,а | 1,400,000.00 | 1,161,600.00 | 238,400.00 | 83.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, | 950,000.00 | 843,500.00 | 106,500.00 | 88.8 |
| | нормативт зардал | 19,292,200.00 | 18,198,170.00 | 1,094,030.00 | 94.3 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,412,200.00 | 13,412,200.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | хоол хүнс | 4,000,000.00 | 3,999,970.00 | 30.00 | 100.0 |
| 210503 | нормын хувцас зөөлөн эдлэл | 1,880,000.00 | 786,000.00 | 1,094,000.00 | 41.8 |
| | Эд хогшил худалдан авах | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| | Томилолт,зочны зардал | 1,657,200.00 | 1,494,300.00 | 162,900.00 | 90.2 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,657,200.00 | 1,494,300.00 | 162,900.00 | 90.2 |

/Эх сурвалж: 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www. shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан байна. 4 мэдээ нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас хугацаа хоцорч мэдээлсэн байна

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | | 3 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 4 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 1 | 36 | 36 | | |
| 5 | Тухай бүр | 7 | 96 | 92 | 4 | |
| | Нийт | 27 | 151 | 144 | 4 | 3 |

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хугацаанд нь бүрэн биелүүлж, 100 хувийн биелэлттэй байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, НББББ боловсруулж мөрдөж ажиллах 2 заалт бүхий зөвлөмж өглөө.

## Залруулсан алдаа

байхгүй

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

.

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Аймгийн ЭМГ-аас тайлант онд 10610,6 мянган төгрөгийн тендерийн эмийг үнэ төлбөргүй нийлүүлснээс эмийн тайланд үнэгүй орлого 6566,7 мянган, тусгай зориулалтын бараа материалд 1881,8 мянган төгрөгийн орлогыг авсан ба тайлант оны эцэст сумын ЭЭС-д 2162,1 мянган төгрөгийн эм байгааг тус байгууллага хүлээн аваагүй тул тайланд тусгаагүй иймд тухайн байгууллагад үлдэгдлээр байгаа эмийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

## Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

***1.1.1.Өгсөн зөвлөмж:*** *Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2 мэдээлэл, сараар байршуулах 2 төрлийн 2 мэдээлэл, тухай бүр байршуулах нийт 2 төрлийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.*

*Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.*

*1.1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй*

*1.1.3.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны сайтад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан хугацаанд мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*1.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***2.1.1.Өгсөн зөвлөмж:*** *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн" 8.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20,20,2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийн зохион байгуулах" гэсэн заалтуудыг мөрдөж НБББББ-ийг боловсруулж мөрдөж ажиллах. .*

*Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан НБББББ-ийг боловсруул, баталгаажуулж мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.*

*Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06* дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР .................................................. С.САРАНТУЯА
Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР.................................................. А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР.................................................. Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.25



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Хавсралт:Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| 2021 | *2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит* | БНА-2021/37/СТА-ТШЗ |

| Шалгагдсан байгууллагын нэр: | |
|---|---|
| Баянхонгор аймгийн Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төв | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2 мэдээлэл, сараар байршуулах 2 төрлийн 2 мэдээлэл, тухай бүр байршуулах нийт 2 төрлийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Э.Уртнасан Т.Болорцэцэг |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмжийг 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байхад бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. | | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Э.Уртнасан Т.Болорцэцэг |
| **ДҮН** | | | | | |